



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй
болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 59 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хосхолбоо уул ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Компанийн оноосон нэрээс “ББСБ” тэмдэглэгээг хасуулж, үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөхийг “Хосхолбоо уул ББСБ” ХХК /Ч.Отгончимэг/-д үүрэг болгосугай.

3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг хийж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН